34.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.

**35. Тендерийг
үнэлэх,
харьцуулах**

35.1. Захиалагч зөвхөн 31 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.

35.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно:

- (а) 32 дугаар зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;
- (б) 31 дүгээр зүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцож, үнэд залруулга хийх;
- (в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;
- (г) Захиалагч энэ ТББ-ийн 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг холбогдох аргачлалын дагуу тооцож тендерийн үнэд тусгах;
- (д) ТШӨХ-д зөвшөөрснөөр дотоодын давуу эрхийн зөрүү олгох бол холбогдох аргачлалын дагуу тооцох.

35.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 35.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 70 оноо (S_{max}) өгч, бусад тендерт оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараахь томъёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

P_{min} – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендер оролцогчийн үнэ

P_x – Тухайн тендерт оролцогчийн үнэ

S_x – Тухайн тендерт оролцогчийн оноо

S_{max} – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендер оролцогчийн оноо

35.4. Чанарын үнэлгээг дараахь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

35.4.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

35.4.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй бол (SRA):

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

35.4.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол:
Тухайн багцын:
 $0 \leq 50\%$ - 0 оноо;
 $50 \leq 60\%$ - 1 оноо;
 $60 \leq 70\%$ - 2 оноо;
 $70 \leq 80\%$ - 3 оноо;
 $80 \leq 90\%$ - 4 оноо;
 $90 \leq 100\%$ - 5 оноо;

35.4.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол:
Тухайн багцын:
 $0 \leq 50\%$ - 0 оноо;
 $50 \leq 60\%$ - 1 оноо;
 $60 \leq 70\%$ - 2 оноо;
 $70 \leq 80\%$ - 3 оноо;
 $80 \leq 90\%$ - 4 оноо;
 $90 \leq 100\%$ - 5 оноо;

35.4.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт оролцогч үйлдвэрлэдэг бол:
Тухайн багцын:
 $0 \leq 50\%$ - 0 оноо;
 $50 \leq 60\%$ - 1 оноо;
 $60 \leq 70\%$ - 2 оноо;
 $70 \leq 80\%$ - 3 оноо;
 $80 \leq 90\%$ - 4 оноо;
 $90 \leq 100\%$ - 5 оноо;

35.4.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд тендерт оролцогч импортлодог бол:
Тухайн багцын:
 $0 \leq 50\%$ - 0 оноо;
 $50 \leq 60\%$ - 1 оноо;
 $60 \leq 70\%$ - 2 оноо;
 $70 \leq 80\%$ - 3 оноо;
 $80 \leq 90\%$ - 4 оноо;
 $90 \leq 100\%$ - 5 оноо;

35.5. Дотоодын үйлдвэрлэгч 35.4.2, 35.4.3 дахь хэсэгт заасан гэрчилгээтэй гэж үзэн харгалзах оноог өгнө.

35.6. Чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноог 35.3, 35.4-д заасны дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

$$B_x = Q_x + S_x$$

B_x – Тухайн тендерт оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Q_x – Тухайн тендерт оролцогчийн чанарын үнэлгээний оноо

35.7. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

- 35.8. Барааг ТООЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.
- 35.9. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгохдоо захиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэх олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.
- 36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**
- 36.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 36.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТООЗ-ны 18.2–т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 36.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.
- 37. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах**
- 37.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

- 38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**
- 38.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.6-д заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 38.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.
- 39. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл**
- 39.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.
- 39.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

39.3. Захиалагч засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn вэб сайтад тендерийн нэр болон багцын дугаарыг дараахь мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ:

- (1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
- (2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
- (3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
- (4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
- (5) Тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.

39.4. Тендер нь шалгарсан оролцогч ТӨӨЗ-ын 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа болон гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсний дараагаар захиалагч ТӨӨЗ-ын 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож байгаа тухай шалгараагүй бусад тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх

40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.

41. Гэрээнд гарын үсэг зурах

41.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

41.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 6-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

41.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТӨӨЗ-ны 39.2-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

42. Гүйцэтгэлийн баталгаа

42.1. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.

42.2. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно.

42.3. Шалгарсан тендерт оролцогч ТӨӨЗ-ны 42.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах эм, эмнэлгийн хэрэгсэл талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл																																
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: Нийслэлийн Эрүүл мэндийн газар Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл-2; НХААГ-20/0004																																
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл-2; НХААГ-20/0004 <table border="1" data-bbox="501 768 1433 1570" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 20%;">Багцын дугаар</th> <th style="width: 50%;">Төсөл, арга хэмжээний нэр</th> <th style="width: 30%;">Багцын дугаар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц-11</td> <td>Амин дэм, эрдэс бодисууд /Дотоодын үйлдвэр/</td> <td>НХААГ-20/0004-11</td> </tr> <tr> <td>Багц-12</td> <td>Дааврын болон спазмолитик эмүүд</td> <td>НХААГ-20/0004-12</td> </tr> <tr> <td>Багц-13</td> <td>Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд</td> <td>НХААГ-20/0004-13</td> </tr> <tr> <td>Багц-14</td> <td>Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд /Дотоодын үйлдвэр/</td> <td>НХААГ-20/0004-14</td> </tr> <tr> <td>Багц-15</td> <td>Бусад тарилгын эмийн хэлбэрүүд /Дотоодын үйлдвэр/</td> <td>НХААГ-20/0004-15</td> </tr> <tr> <td>Багц-16</td> <td>Үрэвслийн эсрэг, тархины цусан хангамж сайжруулах эмийн хэлбэрүүд</td> <td>НХААГ-20/0004-16</td> </tr> <tr> <td>Багц-17</td> <td>Үрэвслийн эсрэг, тархины цусан хангамж сайжруулах эмийн хэлбэрүүд /Дотоодын үйлдвэр/</td> <td>НХААГ-20/0004-17</td> </tr> <tr> <td>Багц-19</td> <td>Инсулин ба чихрийн шижингийн эсрэг тарилга</td> <td>НХААГ-20/0004-19</td> </tr> <tr> <td>Багц-20</td> <td>Чихрийн шижин болон чихрийн бус шижин өвчний үед хэрэглэх эмүүд</td> <td>НХААГ-20/0004-20</td> </tr> </tbody> </table> <p data-bbox="469 1615 1466 1767">Жич: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10^{1.1}-т заасны дагуу чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахыг хориглоно.</p>			Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын дугаар	Багц-11	Амин дэм, эрдэс бодисууд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-11	Багц-12	Дааврын болон спазмолитик эмүүд	НХААГ-20/0004-12	Багц-13	Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд	НХААГ-20/0004-13	Багц-14	Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-14	Багц-15	Бусад тарилгын эмийн хэлбэрүүд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-15	Багц-16	Үрэвслийн эсрэг, тархины цусан хангамж сайжруулах эмийн хэлбэрүүд	НХААГ-20/0004-16	Багц-17	Үрэвслийн эсрэг, тархины цусан хангамж сайжруулах эмийн хэлбэрүүд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-17	Багц-19	Инсулин ба чихрийн шижингийн эсрэг тарилга	НХААГ-20/0004-19	Багц-20	Чихрийн шижин болон чихрийн бус шижин өвчний үед хэрэглэх эмүүд	НХААГ-20/0004-20
Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын дугаар																															
Багц-11	Амин дэм, эрдэс бодисууд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-11																															
Багц-12	Дааврын болон спазмолитик эмүүд	НХААГ-20/0004-12																															
Багц-13	Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд	НХААГ-20/0004-13																															
Багц-14	Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-14																															
Багц-15	Бусад тарилгын эмийн хэлбэрүүд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-15																															
Багц-16	Үрэвслийн эсрэг, тархины цусан хангамж сайжруулах эмийн хэлбэрүүд	НХААГ-20/0004-16																															
Багц-17	Үрэвслийн эсрэг, тархины цусан хангамж сайжруулах эмийн хэлбэрүүд /Дотоодын үйлдвэр/	НХААГ-20/0004-17																															
Багц-19	Инсулин ба чихрийн шижингийн эсрэг тарилга	НХААГ-20/0004-19																															
Багц-20	Чихрийн шижин болон чихрийн бус шижин өвчний үед хэрэглэх эмүүд	НХААГ-20/0004-20																															
ТӨӨЗ 1.4	Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг Дараа жилийн гэрээ байгуулах хүртэл бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын эмийн сангийн агуулахад хүргэх үүрэгтэй.																																

ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөв Нийт төсөвт өртөг - 9,286,306,493 /есөн тэрбум хоёр зуун наян зургаан сая гурван зуун зургаан мянга дөрвөн зуун ерэн гурав/ төгрөг		
	Багцын дугаар	Төсөвт өртөг /төгрөг/	Төсөвт өртөг /тоогоор/
	Багц-11	105,776,900	Нэг зуун таван сая долоон зуун далан зургаан мянга есөн зуу
	Багц-12	120,647,800	Нэг зуун хорин сая зургаан зуун дөчин долоон мянга найман зуу
	Багц-13	105,438,000	Нэг зуун таван сая дөрвөн зуун гучин найман мянга
	Багц-14	28,371,600	Хорин найман сая гурван зуун далан нэгэн мянга зургаан зуу
	Багц-15	211,856,400	Хоёр зуун арван нэгэн сая найман зуун тавин зургаан мянга дөрвөн зуу
	Багц-16	82,671,100	Наян хоёр сая зургаан зуун далан нэгэн мянга нэг зуу
	Багц-17	25,008,900	Хорин таван сая найман мянга есөн зуу
	Багц-19	105,920,000	Нэг зуун таван сая есөн зуун хорин мянга
	Багц-20	483,072,000	Дөрвөн зуун наян гурван сая далан хоёр мянга
Нийт	1,268,762,700	Нэг тэрбум хоёр зуун жаран найман сая долоон зуун жаран хоёр мянга долоон зуу	
ТӨӨЗ 4.2.2	<p>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Захиалагч цахим системээр дамжуулан тендерт оролцогчдын татвар төлөлтийн мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байхаар тооцож шалгана. • Харъяа нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ. • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ. <p>Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</p>		
ТӨӨЗ 4.2.4	Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт ирүүлэх, /Энэхүү тодорхойлолтод Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын талаар тусгасан байх		
ТӨӨЗ 4.3	ТӨӨЗ-ны 4.2.1-4.2.9-д дурьдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл ирүүлнэ.		
Б. Тендерийн баримт бичиг			
ТӨӨЗ 6.1	<p>Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Түншлэлийн гэрээ /Түншлэлийн гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тусгасан байх, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үнийн дүн, хувийг тодорхой тусгасан байна./ 2. Цахим системд нэвтрэх эрх, тоон гарын үсэг авсан тендерт оролцогч нь журмын 5.1-д заасны дагуу тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр цахим худалдан авах ажиллагаанд дараах байдлаар оролцоно. <ul style="list-style-type: none"> • Тендерт оролцогч нь түншлэлээр оролцох бол талууд цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байх; 		

	<ul style="list-style-type: none"> Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө тендерээ электрон хэлбэрээр буюу “PDF” форматаар гаргацтай, тод хөрвүүлж илгээх, ингэхдээ өөрийн санал болгож буй тендерийн үнэ, хүчинтэй хугацаа болон холбогдох бусад мэдээллийг системийн холбогдох талбарт бүрэн оруулсан байх зэрэг хуулийн 53.5.4-т заасны дагуу мэргэжлийн байгууллагаас тогтоосон бусад аргачлал, зааврыг баримталж тендер илгээх; Шаардлагатай гэж үзвэл тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендертээ засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах, буцаан авах.
ТӨӨЗ 8.1	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 6-аас доошгүй хоногийн өмнө Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвүүдээр дамжуулан хүлээн авна. Үүнд:</p> <p>1. Мишээл салбар: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 2 дугаар хороо, Мишээл барилгын их дэлгүүрийн баруун жигүүр Б Блок, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв /Мишээл салбар/ Холбоо барих утас: 75751200</p> <p>2. Дүнжингарав салбар: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Дүнжингарав худалдааны төвийн D2 блок, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв /Дүнжингарав салбар/ Холбоо барих утас: 75751200</p> <p>3. Драгон салбар: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо, Драгон төвийн зүүн жигүүр Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв /Драгон салбар/ Холбоо барих утас: 75771200</p> <p>4. Оргил салбар: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо, 6 буудал, Оргил худалдааны төвийн байр /Оргил салбар/ Холбоо барих утас: 75851300</p> <p>Тодруулгын хариуг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д байрлуулна.</p>
ТӨӨЗ 9	<p>Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.</p> <p>Тендерийн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.</p>
В. Тендер бэлтгэх	
ТӨӨЗ 11.1	Тендерийн хэл нь: Монгол хэл байна.
ТӨӨЗ 11.2	<p>Тендерийн дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТӨӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.</p> <p><i>Баримт бичгүүд нь Монгол хэлнээс бусад хэл дээр байгаа тохиолдолд баталгаат орчуулгын товчоогоор орчуулга хийлгэн тухай бүрт хаасарган ирүүлнэ. Ирүүлээгүй нь татгалзах үндэслэл болно.</i></p>
ТӨӨЗ 12.1 (a) – (ё)	<p>12.1 (a) - (ё)-д заасан баримт бичгээс гадна дараах материалыг нэмж бүрдүүлнэ:</p> <p>(a) Тендерийн маягт болон үнийн хуваарь;</p> <p>(б) Тендерийн баталгаа;</p> <p>(в) Тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;</p> <p>(г) ТӨӨЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд</p> <ul style="list-style-type: none"> Улсын бүртгэлийн гэрчилгээ; Тусгай зөвшөөрөл; <p>(д) ТӨӨЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;</p> <ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл;

	<ul style="list-style-type: none"> • Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл; • Хийж гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл; • Гологдол гарсан тухай бүрт яаралтай дутагдалыг арилгах; • Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө; • Харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл; • Тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл; • туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл; <p>(е) ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;</p> <ul style="list-style-type: none"> • Барааны техникийн болон ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт; • Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн тухай мэдэгдэл; <p>(ё) ТООЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх бусад материал.</p> <ul style="list-style-type: none"> • Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй тухай тодорхойлолт ирүүлнэ. • Тендерийн баримт бичиг, гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрсөн албан мэдэгдэл ирүүлнэ. • Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтааж бараа захиалагчид нийлүүлэх баталгаа бичгээр ирүүлнэ. • Харьялагдах татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ. • Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. <p>Дээрх баримт бичгүүдийг тухайн багцад шаардлагатай материалыг PDF хэлбэрт шилжүүлэн тод гаргацтай ирүүлнэ. Уг шаардлагыг хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТООЗ 13.1	Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягт №ТШМ-1 -ийг бөглөж ирүүлнэ. Тендерийн маягтын үг, өгүүлбэрийг өөрчлөх буюу орхигдуулбал тендерээс татгалзах үндэслэл болно.
ТООЗ 13.2	Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягыг ашиглан бэлтгэнэ.
ТООЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй” .
ТООЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс-ийн хувилбар: “Incoterms 2010”
ТООЗ 15.9 (a) (3);(б)(3) болон (в)(5)	“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгүүдийн эмийн сангийн агуулах.
ТООЗ 15.9 (б) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТООЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан CIP үнээс гадна дараах үнээр санал болгож болно. Үүнд: Энэ үнэнд НӨАТ, Гаалийн татвар, даатгал, тээврийн зардал багтсан байна.
ТООЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй тогтмол байна.”
ТООЗ 16.1	Тендерийн валют: Төгрөг байна.
ТООЗ 17.1 (a)	Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлнэ.

ТӨЭЗ 17.1 (б)	Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг бүлэг 4-т заасан маягтын дагуу гаргаж ирүүлнэ.															
ТӨЭЗ 17.1 (в)	Тусгай зөвшөөрөл: “Шаардлагатай” Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас олгогддог: - Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, худалдах тусгай зөвшөөрөл. - Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл. /Дээр заагдсан заалтуудаас тендер ирүүлж буй багцад хамааралтай тусгай зөвшөөрлийн эх хувиас хийсэн хуулбарыг ирүүлэх/ Түншлэл болон туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх ажил үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.															
ТӨЭЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “шаардлагатай” /Маягт №ТМ-4-ийн дагуу байх бөгөөд ирүүлэх он, сар, өдөр нь энэ худалдан авалтад зориулан ирүүлсэн байна./															
ТӨЭЗ 18.1 (б)	Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын санхүүгийн тайлангаас шаардлагатай мэдээллийг татаж үзнэ.															
ТӨЭЗ 18.1 (в)	Дараах хүснэгтэд үзүүлсэн голлох болон инженер техникийн ажилтныг ажиллуулна. <table border="1" data-bbox="504 943 1430 1043"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Эм зүйч</td> <td>2</td> <td>2 болон түүнээс дээш</td> <td>Эм зүйч</td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> - Дээрх ажилтнуудын сургууль төгссөн диплом, эм барих гэрчилгээ, иргэний үнэмлэхний өнгөт хуулбарыг ирүүлнэ. - Тухайн ажилтны ажлын туршлагыг баталгаажуулахын тулд нийгмийн даатгалын дэвтрийн даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, шаардагдсан жилийн нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг ирүүлнэ. 	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	1	Эм зүйч	2	2 болон түүнээс дээш	Эм зүйч					
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил												
1	Эм зүйч	2	2 болон түүнээс дээш	Эм зүйч												
ТӨЭЗ 18.1 (г)	Нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нийт мөнгөн дүнг жил, жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг ирүүлнэ. <table border="1" data-bbox="504 1397 1430 1514"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих, утас/факс</th> <th>Төсөвт өртөг</th> <th>Дууссан, эсхүл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих, утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа	1					2				
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих, утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа												
1																
2																
ТӨЭЗ 18.1 (ё)	Харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлэх															
ТӨЭЗ 18.1 (ж)	Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: Шаардлагатай: Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлнэ.															
ТӨЭЗ 18.1 (з)	Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хүртэл хувь байна. Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба түншлэлийн гишүүн нь ТӨЭЗ-нд дурдсан бусад шалгуурыг хангасан байх шаардлагатай.															
ТӨЭЗ 18.2	Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт: Дараах баримт бичгүүдийг тендерт заавал хавсаргана. <i>Тендер нь шалгарсан тохиолдолд тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэхэд дараах нөхцөл байдлыг нотлох баримт бичиг шаардагдана:</i>															

	<p>(i) <i>Хэрэв тендерт оролцогч нь гэрээний дагуу өөрийн үйлдвэрлэсэн барааг нийлүүлж буй бол:</i></p> <p>(a) тендерт оролцогч нь бараа үйлдвэрлэгдсэн улсад үйл ажиллагаа явуулдаг;</p> <p>(б) тухайн орны эрх бүхий байгууллагаас тухайн барааг нийлүүлэх эрхийг авсныг;</p> <p>(в) тендерийн баримт бичигт заагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг 2-оос доошгүй жил, ижил төрлийн барааг 5-аас доошгүй жил үйлдвэрлэж, борлуулсныг;</p> <p>(г) ДЭМБ-ын GMP-ийн сертификат эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсад худалдаанд гаргах эрхийг тухайн орны зохицуулах эрх бүхий этгээдээс авсан, эсхүл PIC-ийн гишүүн орны эрх бүхий этгээдээр баталгаажсан бөгөөд тендер ирүүлэх хүртэлх сүүлийн 2 жилд чанарын стандартын шалгалт хийгдсэнийг;</p> <p>(ii) <i>Хэрэв тендерт оролцогч нь нийлүүлж буй бараагаа өөрөө үйлдвэрлээгүй бол,</i></p> <p>(a) Тендерт оролцогч нь барааг нийлүүлэх зөвшөөрлийг үйлдвэрлэгч эсхүл гэрээт борлуулалгчаас албан ёсоор авсан буюу Монгол улсад тухайн барааг нийлүүлэх шалгууруудыг хангасныг нотлох баримтийг ирүүлэх;</p> <p>(б) Шаардлагатай бол GDP (Good Distribution Practice)-ийн сертификат авсныг нотлох баримтийг ирүүлэх.</p> <p>Тендерт оролцогч нь дараах нэмэлт мэдээллийг хавсаргана:</p> <p>(a) Үйлдвэрлэлийн хүчин чадлын мэдээлэл;</p> <p>(в) Газар дээр нь хийгдсэн чанарын хяналтын байгууламж үйлчилгээний үзүүлэлтийн талаарх мэдээлэл, болон хийгдсэн шинжилгээний цар хүрээ;</p> <p>(г) Тендерт оролцогчийн үйлдвэрлэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гэрчилгээний хамт /Тусгай зөвшөөрлийн дугаар, огноо/;</p> <p>(д) ДЭМБ-ын журмын дагуу барааны нэр төрөл тус бүрд авсан эм, эмнэлгийн хэрэгслийн сертификат.</p> <p>Санамж: Хэрэв тендер шалгаруулалт нэгээс дээш багцтай бол тодорхой багцад эсхүл олон багцад тавигдах чадварын шалгуурыг шаардлагатай бол тусгайлан заана.</p>
<p>ТӨӨЗ 18.2 (a)</p>	<p>Борлуулалтын орлогын хэмжээ:</p> <p>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь багц тус бүрийн төсөвт өртгийн 50%-аас багагүй байна.</p>
<p>ТӨӨЗ 18.2 (б)</p>	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:</p> <p>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд багц тус бүрийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй доод тал нь нэг эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлсэн байх.</p> <p>Нийлүүлсэн гэрээ болон захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.</p>
<p>ТӨӨЗ 18.2 (г)</p>	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:</p> <p>Багц тус бүрийн төсөвт өртгийн 30%-аас багагүй байх.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ 2. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/. 3. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн

	тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар"-ын 3.2.2 /e/-д "Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө = Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ" гэж заасны дагуу тодорхойлно.
ТӨӨЗ 18.3	<p>Тендерт оролцогч 18.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ.</p> <p>Гэхдээ гишүүн тус бүр 18.2 (а), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана.</p> <p>ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.</p> <p>Тендерт оролцогч 18.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.</p>
ТӨӨЗ 18.4	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцно.</p> <p>"Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлт болон Давуу эрх тооцуулах материалуудыг хавсарган ирүүлэх ба Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 болон 10' дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 58 дугаар тушаалын хавсралтад заасан "Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал"-ын дагуу тооцно."</p>
ТӨӨЗ 19.1	<p>Эм, эмнэлгийн хэрэгслийн техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт: Шаардлагатай.</p> <p>Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэлийг баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 19.2	<ol style="list-style-type: none"> Тендерт оролцогч нь үйлдвэрлэгч орны зохицуулагч эрх бүхий этгээдээс эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх эрхийг баталгаажуулсан гэрчилгээг хавсаргасаж ирүүлнэ. Эм тус бүр дээр Фармакопейн шаардлага хангасныг нотлох баримт /Шинжилгээний сертификатуудын хуулбар/, Дотоодын үйлдвэрлэгчийн хувьд лабораториар баталгаажуулсан шинжилгээний гэрчилгээг ирүүлнэ. Өөрөө үйлдвэрлээгүй эм, эмнэлгийн хэрэгсэл санал болгох тохиолдолд уг эм, эмнэлгийн хэрэгслийг: Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн /Маягт ТМ-4-ийн дагуу/ болон гэрээт борлуулагчийн зөвшөөрөл /Гэрээт борлуулагч нь тухайн эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэхээр үйлдвэрлэгчээс авсан албан ёсны зөвшөөрлийн хамт/ ирүүлнэ. <p>Эм, эмнэлгийн хэрэгсэл нь техникийн тодорхойлолтод тусгайлан заагдсан стандартуудыг болон ДЭМБ-ын GMP, ISO шаардлагыг аль нэгийг хангасан байна.</p>
ТӨӨЗ 19.4	<ol style="list-style-type: none"> Эмийн бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлнэ. Гэрээний дагуу нийлүүлэх эм нь Монгол улсын эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн байх ба Эмнэлгийн хэрэгслийн хувьд сертификатыг хавсаргаж ирүүлнэ.

	<p>3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн болон нийлүүлэлтийн шаардлагын хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>4. Нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн бүтээгдэхүүний сертификат /Маягт №ТМ-6-ийн дагуу/</p> <p>Импортын лиценз, үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээ, гэрээний хавсралтын /нэр төрөл, үйлдвэрлэгч болон үнийн дүнгээр/ хуулбаруудыг ирүүлнэ.</p>																														
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.																														
ТӨӨЗ 21	<p>Тендерийн баталгааны үнийн дүн:</p> <table border="1" data-bbox="523 445 1442 831"> <thead> <tr> <th>Багцын дугаар</th> <th>Баталгаа дүн /төгрөг/</th> <th>Баталгааны дүн /тоогоор/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц-11</td> <td>1,100,000</td> <td>Нэг сая нэг зуун мянга</td> </tr> <tr> <td>Багц-12</td> <td>1,210,000</td> <td>Нэг сая хоёр зуун арван мянга</td> </tr> <tr> <td>Багц-13</td> <td>1,060,000</td> <td>Нэг сая жаран мянга</td> </tr> <tr> <td>Багц-14</td> <td>284,000</td> <td>Хоёр зуун наян дөрвөн мянга</td> </tr> <tr> <td>Багц-15</td> <td>2,200,000</td> <td>Хоёр сая хоёр зуун мянга</td> </tr> <tr> <td>Багц-16</td> <td>830,000</td> <td>Найман зуун гучин мянга</td> </tr> <tr> <td>Багц-17</td> <td>260,000</td> <td>Хоёр зуун жаран мянга</td> </tr> <tr> <td>Багц-19</td> <td>1,100,000</td> <td>Нэг сая нэг зуун мянга</td> </tr> <tr> <td>Багц-20</td> <td>4,900,000</td> <td>Дөрвөн сая есөн зуун мянга</td> </tr> </tbody> </table> <p>Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хүчинтэй байна.</p> <p>Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.</p> <p>Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ○ тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн; ○ тендерт оролцогч 32.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ТӨӨЗ-ын 38.2-т заасан нөхцөл үүссэн бол; ○ шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан: <ol style="list-style-type: none"> (1) ТӨӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй; (2) ТӨӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй. ○ тендерт оролцогчийн гаргасан гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн. <p>Тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй.</p> <p>Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 2.1 дэх хэсэгт заасны дагуу Захиалагч тендерийн баталгааг хуулийн 20.6-д зааснаар «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулсны дараа цахим системээр хүчингүй болгоно. Мөн тус журмын 2.2 дахь хэсэгт заасны дагуу хэд хэдэн багцтай тендер шалгаруулалтын баталгааг багц тус бүрээр гаргах бөгөөд цахим системээр гаргаж буй тендерийн баталгааг тендерт оролцогч бичгээр гаргуулах, үнэт цаасан дээр хэвлүүлэх шаардлагагүй.</p>	Багцын дугаар	Баталгаа дүн /төгрөг/	Баталгааны дүн /тоогоор/	Багц-11	1,100,000	Нэг сая нэг зуун мянга	Багц-12	1,210,000	Нэг сая хоёр зуун арван мянга	Багц-13	1,060,000	Нэг сая жаран мянга	Багц-14	284,000	Хоёр зуун наян дөрвөн мянга	Багц-15	2,200,000	Хоёр сая хоёр зуун мянга	Багц-16	830,000	Найман зуун гучин мянга	Багц-17	260,000	Хоёр зуун жаран мянга	Багц-19	1,100,000	Нэг сая нэг зуун мянга	Багц-20	4,900,000	Дөрвөн сая есөн зуун мянга
Багцын дугаар	Баталгаа дүн /төгрөг/	Баталгааны дүн /тоогоор/																													
Багц-11	1,100,000	Нэг сая нэг зуун мянга																													
Багц-12	1,210,000	Нэг сая хоёр зуун арван мянга																													
Багц-13	1,060,000	Нэг сая жаран мянга																													
Багц-14	284,000	Хоёр зуун наян дөрвөн мянга																													
Багц-15	2,200,000	Хоёр сая хоёр зуун мянга																													
Багц-16	830,000	Найман зуун гучин мянга																													
Багц-17	260,000	Хоёр зуун жаран мянга																													
Багц-19	1,100,000	Нэг сая нэг зуун мянга																													
Багц-20	4,900,000	Дөрвөн сая есөн зуун мянга																													
ТӨӨЗ 22.4	<p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.</p> <p>Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>																														
Г. Тендер ирүүлэх																															

ТОӨЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50.000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.
ТОӨЗ 23.3 (в)	Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Нэр, дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын 2020 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл-2, НХААГ-20/0004 Жич: Баримт бичгүүдийг тухайн багцад шаардлагатай материалыг PDF хэлбэрт шилжүүлэн тод гаргацтай ирүүлнэ. Уг шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн баримт бичгийг үнэлгээнд харгалзан үзэхгүй.
